



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн ажлаа чадварлаг санаачлагатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн байх /хамт олны хурлын тэмдэглэл/;
 2. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 3-с доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх /баримтуудыг хавсаргасан байх/;
 3. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд 3-с доошгүй өгүүллийг 1-р зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх /баримтуудыг хавсаргасан байх/;
 4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтад хамрагдсан, сүүлийн 5 жил тус бүр 2 багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил тус бүрээр хавсаргах/;
 5. Мэргэшлийн зэрэг горилогчийн өргөдлийн маягтаас гадна хавсаргасан Хавсралт 1-ийг бөглөн байгууллагын удирдлага, хамт олны хурлаар хэлэлцүүлэн, дэмжлэг авч, зөвшөөрч тодорхойлсон байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн ажлаа чадварлаг, санаачлагатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн байх /хамт олны хурлын тэмдэглэл/;
 2. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 5-аас доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх /баримтуудыг хавсаргасан байх/;
 3. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээний мэргэжлийн сэргүүлд 5-аас доошгүй өгүүллийг 1-р

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх /баримтуудыг хавсаргасан байх/;

4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтад хамрагдсан, сүүлийн 5 жил тус бүр 2 багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил тус бүрээр хавсаргах/.